

**Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал
/2023 оны 01 дүгээр сар/**


Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 18 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар тодорхойлдог.

Улаанбаатар хотын 2023 оны хүйтний улирал 01 дүгээр сарын агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2022 оны 01 дүгээр сарын дундаж агууламжтай харьцуулахад PM10 тоосонцор 7 мкг/м³-ээр буюу 5 %-иар бага, харин PM2.5 тоосонцор 8 мкг/м³-ээр буюу 8 %-иар, азотын давхар исэл (NO₂) нь 4 мкг/м³-ээр буюу 6 %-иар, хүхэрлэг хий (SO₂) нь 6 мкг/м³-ээр буюу 4 %-иар тус тус их байна.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2022 оны 01 дүгээр сар	2023 оны 01 дүгээр сар
PM10 тоосонцор	100	146	139
PM2.5 тоосонцор	50	102	110
Азотын давхар исэл, NO ₂	50	61	65
Хүхэрлэг хий, SO ₂	50	163	169

Улаанбаатар хотын сүүлийн 6 жил буюу 2018-2023 оны 01 дүгээр сарын хүйтний улирлын гол бохирдуулах бодис тус бүрийн агууламжийг дараах хэсэгт дэлгэрэнгүй үзүүлээ.


PM10 тоосонцор



Зураг 1. Хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж агууламж, 2018-2023 он

Агаар дахь PM10 тоосонцрын 2023 оны 01 дүгээр сарын дундаж агууламж 139 мкг/м³ байна. Өмнөх оны мөн үе буюу 2022 оны 01 дүгээр сарын дундаж агууламжтай харьцуулахад 5 %-иар бага. Харин агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 1.3 дахин их байна. (Зураг 1).


PM2.5 тоосонцор



Зураг 2. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2018-2023 он

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцор 2023 оны 01 дүгээр сарын дундаж агууламж 110 мкг/м³ байна. Өмнөх оны мөн үе буюу 2022 оны 01 дүгээр сарын дундаж агууламжтай харьцуулахад 8%-иар их. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 2.2 дахин их байна. (Зураг 2).


Азотын давхар исэл (NO₂)



Зураг 3. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2018-2023 он

Азотын давхар ислийн 2023 оны 01 дүгээр сарын дундаж агууламж 65 мкг/м³ байна. Өмнөх оны мөн үе буюу 2022 оны 01 дүгээр сарын дундаж агууламжтай харьцуулахад 6%-иар их. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 1.3 дахин их байна. (Зураг 3).

Хүхэрлэг хий (SO₂)



Зураг 4. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2018-2023 он

Агаар дахь хүхэрлэг хийн 2023 оны 01 дүгээр сарын дундаж агууламж 169 мкг/м³ байна. Өмнөх оны мөн үе буюу 2022 оны 01 дүгээр сарын дундаж агууламжтай харьцуулахад 4%-иар их. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 3.3 дахин их байна. (Зураг 4).

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС